



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СҮХБААТАР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМД**

2024.08.05 № ГНАГ-2024/13-ШТА-НА-31
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.


Дүгнэлт

Ардчилсан намын Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сүхбаатар сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр (.....⁹..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сүхбаатар сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР




ШИНЭ БОДЛОГО-ШИНЭ ХӨГЖИЛ

“СҮХБААТАР СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”

2024 он

- 1 -

Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит
Сонгуульд Сүхбаатар сумын Ардчилсан намаас дэвшүүлж буй
“ШИНЭ БОДЛОГО – ШИНЭ ХӨГЖИЛ” мөрийн хөтөлбөр



Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, нутгийн удирдлага, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд :

Иргэн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Сүхбаатар сумыг хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах хувь хүний эрх чөлөө;
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал;
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН АРДЧИЛСАН НАМ 2024 оны орон нутгийн ИТХ-ын сонгуульд “Шинэ бодлого – шинэ хөгжил” хэмээх уриатайгаар мөрийн хөтөлбөрөө 3 бүлэг, 12 дэд сэдэвтэй боловсруулан та бүхэнд танилцуулж байна.

НЭГ. ХУВЬ ХҮН, НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

1.1. Өрсөлдөх чадвартай боловсрол


- 1.1.1. Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг Сүхбаатар суманд хэрэгжүүлнэ.
- 1.1.2. Гадаадын их дээд сургуульд шилдэг сурагчдыг оюутны тэтгэлгээр суралцах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 1.1.3. Хүүхэд залуучуудыг хөгжүүлэх “СЭЛЭНГЭ STEAM” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /Шинжлэх ухаан, технологи, инженер, урлаг, математик хөгжил/
- 1.1.4. Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын багш, эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтан нарын мэргэжил мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор гадаадын түнш орнуудтай хамтарч ажиллана.
- 1.1.5. Иргэний боловсролыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.

1.2. Эрүүл мэндийн үйлчилгээ

- 1.2.1. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 1.2.2. Сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай чанар хүртээмжтэй, ил тод, ёс зүйтэй, иргэддээ ээлтэй болгох санал санаачилга гаргаж ажиллана.
- 1.2.3. Холбогдох байгууллагуудтай хамтран Сүхбаатар сум орчмын байгалийн үзэсгэлэнт газарт сувиллын барилгыг барьж, ашиглалтад оруулана.
- 1.2.4. Иргэдийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах талаар эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 1.2.5. Эмийн хэрэглээ, хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулахад холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 1.2.6. Сүхбаатар сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг судалж, хэрэгжүүлнэ.

1.3. Хүн амын өсөлт, хөгжил

- 1.3.1. Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн насны хүүхдийг хүмүүжүүлэх бодлого, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд, ээж аавтайгаа хамт хүмүүжиж төлөвших хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

- 
- 1.3.2. Гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг бүрдүүлэх бодлого баримтална.
 - 1.3.3. Сүхбаатар суманд хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжиж ажиллана.
 - 1.3.4. Сүхбаатар сумын гэр хорооллын дахин төлөвлөлтийг ипотекийн зээлтэй уялдуулан үе шаттай хэрэгжүүлнэ.
 - 1.3.5. Сумын иргэдээ зээлийн хөнгөлөлттэй нөхцөлөөр хувийн орон сууцтай болгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх бодлого баримтална.
 - 1.3.6. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд сумын хэмжээнд залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн өрхийг түрээсийн орон сууцаар хангах чиглэл барьж ажиллана.
 - 1.3.7. Жендерт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал, бэлгийн дарамтыг арилгах санал санаачилгыг дэмжинэ.

1.4. Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт

- 1.4.1. Сумын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
- 1.4.2. Суманд гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэх экосистем (санхүүжилт, сургалт, мэдээлэл, г.м.)-ийг бүрдүүлнэ.
- 1.4.3. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Сүхбаатар суманд дамжин өнгөрөх жуулчид хүлээн авах хүчин чадлыг өсгөж, аялал жуулчлалын салбарт ажиллагсдын тоог нэмэгдүүлнэ.
- 1.4.4. Их, дээд болон коллеж төгссөн мэргэжилтэй боловсон хүчнийг Сүхбаатар суманд тогтвор, суурьшилтай ажиллуулах бодлогыг баримталж ажиллана.

1.5. Нийгмийн хамгаалал

- 1.5.1. Нийгмийн халамжийг шаардлагатай өрх, иргэд рүү төвлөрүүлж, зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлнэ.
- 1.5.2. Сумын ахмадын сувиллыг сэргээн, ажиллах нөхцөлийг сайжруулна.
- 1.5.3. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 1.5.4. Бизнесийн байгууллага, хувь хүмүүсийн нийгмийн халамжийн салбарт хийж буй сайн дурын ажлыг бодлогоор дэмжинэ.

1.5.5. Сүхбаатар сумын төрийн үйлчилгээний байгууллагуудад “Хүртээмжийн үнэлгээ” хийлгэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөл боломжоор хангана.

1.6. Соёл , урлаг , спорт

1.6.1. Спортын улсын чанартай томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулах, оролцоход бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.

1.6.2. Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.6.3. Мэргэжлийн спортын төрлүүдээр амжилт гаргаж буй клубүүдийг амжилтаар нь дэмжих бодлого баримтална.

1.6.4. Сумын төвийн зам дагуу дугуйн зам барих санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулан хэрэгжүүлнэ.

1.6.5. Бясалгал, хийн дасгал, нийтийн бүжиг, иог, чөлөөт цагийн клубүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

1.6.6. Сүхбаатар сумын хүүхэд, залуучуудын спорт соёл амралтын хүрээлэн барих ажлыг судалж, холбогдох шатны төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

1.6.7. Сүхбаатар суманд хөл бөмбөгийн орчин үеийн шийдэлтэй стандартад нийцсэн талбай барих санаачилга гарган, санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулан хэрэгжүүлнэ.

ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

2.1. Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа

2.1.1. Сүхбаатар суманд засаглалын зөв механизмыг бүрдүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулан, төрийн албаны мерит зарчмыг баримталж ажиллана.

2.1.2. Орон нутагт ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн жил бүр шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг санаачилсан гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдыг бүх талаар дэмжиж ажиллана.

2.1.3. Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн сан үүсгэж, гарааны бизнесийг бодлогоор дэмжиж ажиллана.

2.1.4. Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл, баялаг бүтээгчдийг дэмжих орон нутгийн бизнес, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.

2.1.5. Суманд оруулж буй гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, хамтран ажиллана.

2.1.6. Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуйн нэгжүүддээ үйлчилдэг, зөвлөж ажиллах санаачилгыг дэмжинэ.

2.2. Төсөв, санхүү, татварын бодлого

2.2.1. Төсвийн тухай хуулийн хүрээнд сумын төсвийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.2. Орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг бий болгож, мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримталж ажиллана.

2.2.3. Хуримтлалыг бий болгох, санхүүгийн эрсдэлээс хамгаалах сургалт-мэдээллийн бодлого хэрэгжүүлнэ.

2.2.4. Иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн үр өгөөжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.

2.3. Үйлдвэрлэл

2.3.1. Сүхбаатар суманд загас, загасан бүтээгдэхүүн нөөшлөх жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

2.3.2. Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, борлуулалтын сүлжээ бий болгох чиглэлээр Солонгос, Япон зэрэг өндөр хөгжилтэй орнуудын туршлагыг орон нутагтаа нутагшуулна.

2.3.3. Нийтийн орон сууцны оршин суугчдад хүнсний хэрэгцээгээ хангах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор дөрвөн улирлын төвлөрсөн хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, ногоо тариалах газрын асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.

2.3.4. Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын зан үйл, хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.3.5. Сумын хүн амыг эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан цэвэр усаар хангах, дэд бүтцийг сайжруулах асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, санхүүжилтийг шийдвэрлүүлнэ.


2.3.6. Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

2.3.7. Жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг гадаад, дотоодын бизнесийн байгууллагуудтай хамтарч ажиллах, туршлага судлах ажлыг бодлогоор дэмжинэ.

2.4. Дэд бүтэц, эрчим хүч, барилга

2.4.1. Сумын батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу дахин төлөвлөлтийн ажлыг дэмжиж, эрчимжүүлнэ.


2.4.2. "Гудамж" төслийг үргэлжлүүлэн, авто замын уулзваруудыг шинэчлэх ажлыг холбогдох төсөвт тусган хэрэгжүүлнэ.

- 
- 2.4.3. Гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцжуулах бодлого баримталж ажиллана.
- 2.4.4. Гэр хорооллын айлуудыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.4.5. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг сайжруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 2.4.6. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг камержуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.4.7. Барилгын материалын үйлдвэрлэл, барилга угсралтын компаниудын үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
- 2.4.8. Барилга, байгууламжийн насжилтыг тогтоож, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан, дахин төлөвлөх ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.4.9. Барилга угсралтын ажилд шаардагдах материалын нийлүүлэлтийн 50-аас доошгүй хувийг орон нутгийн барилгын материал үйлдвэрлэгчдээс худалдан авч үйл ажиллагаа явуулж байгаа барилгын компаниудыг бодлогоор дэмжинэ.
- 2.4.10. Сургууль, цэцэрлэг, дотуур байр, усан бассейн, спорт заалны барилга байгууламжид тавигдах нэгдсэн стандартыг мөрдүүлнэ.
- 2.4.11. Сүхбаатар сумыг цахилгаан эрчим хүчний хоёрдогч эх үүсвэрээр хангах асуудлыг судалж, санхүүжилтийг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 2.4.12. Эмнэлэг, сургууль, цэцэрлэг зэрэг төр, төсвийн байгууллагуудын гаднах авто зогсоолыг шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.4.13. Гэр хорооллын оршин суугчдын түлшний хэрэглээг аюулгүй болгох, агаар дахь хорт хийн хэмжээг эрүүл ахуйн стандартын хэмжээнд байлгах, халаалтын шинэ технологийг нэвтрүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулна.
- 2.4.14. Орчин үеийн технологи бүхий бие даасан дэд бүтэцтэй хувийн орон сууцны хорооллыг бий болгохыг бодлогоор дэмжинэ.

ГУРАВ. ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ СҮХБААТАР

3.1. Иргэдийн оролцоо, тэгш эрх

- 3.1.1. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисоос хамааралтай, донтогч иргэнд эмнэлгийн, сэтгэл зүйн болон нийгмийн тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 3.1.2. Нас, хүйс, хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг гэр бүлийн орчин, ажлын байр, олон нийтийн орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.1.3. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

- 
- 3.1.4. Нийтэд тустай хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, хүртээмжийг сайжруулах бодлого баримтална.
 - 3.1.5. Сумын нутгийн удирдлагын байгууллагын ил тод, нээлттэй байдал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим ИТХ-ыг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.
 - 3.1.6. Иргэд гарын үсэг цуглуулж, тодорхой асуудлыг хөндөж дэвшүүлсэн тохиолдолд сумын ИТХ шууд авч хэлэлцэх боломжийг бий болгоно.
 - 3.1.7. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэнэ.
 - 3.1.8. Төрийн байгууллага, удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд нээлттэй, ил тод, тайлангийн сонсгол хийдэг ажлыг тогтмолжуулна.
 - 3.1.9. Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлнэ.
 - 3.1.10. Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудад тусгасан иргэний оролцоо, хяналтын боломжуудыг бодитоор хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
 - 3.1.11. Аж ахуй эрхлэх, үйлдвэрлэлийг дэмжихэд холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд төрийн байгууллагын хүнд суртлыг арилгах санаачилга гаргаж ажиллана.
 - 3.1.12. Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой, ил тод нээлттэй болгох талаар онцгой анхаарч ажиллана.

3.2. Аюулгүй орчинтой Сүхбаатар

- 3.2.1. Иргэн бүрийн аюулгүй байдлаа хангахад хэрэгтэй мэдлэг, мэдээллийг нийгэмд түгээж, иргэдийн оролцоог дэмжинэ.
- 3.2.2. Сүхбаатар сумын үерийн хамгаалалтын даланг шинэчлэх ажлын санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулж, хэрэгжүүлнэ.
- 3.2.3. Инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлын стандартыг хангуулахад холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 3.2.4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ.
- 3.2.5. Гэр хорооллын түүхий нүүрсний хэрэглээг багасгаж, шахмал түлшний хэрэглээг бодлогоор дэмжинэ.

- 3.2.6. Ногоон орчин бүрдүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.2.7. Сүхбаатар сумын ногоон байгууламжийг 50 хувь нэмэгдүүлнэ.
- 3.2.8. Сүхбаатар суманд ногоон байгууламжийн услалтын системийг бий болгох асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 3.2.9. Хөрсний бохирдлыг багасгах зорилгоор гэр хорооллын оршин суугчдад "Жорлонгоо өөрчилъе" төслийг холбогдох байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.
- 3.2.10. Гамшиг, аюулаас хамгаалах сумын штаб болон орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

СҮХБААТАР СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО